



**СЕРВЕР ӨРГӨЖҮҮЛЭХ, КАМЕРЖУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: **СЕРВЕР ӨРГӨЖҮҮЛЭХ, КАМЕР
ХУДАЛДАН АВАХ**

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: **ЗТГОНӨААТҮГ /202001012**

2020 ОН

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **/СЕРВЕР ӨРГӨЖҮҮЛЭХ, КАМЕР** /нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /ADOBE PDF/шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ.

Тендерийн дугаар: ЗТГОНӨААТҮГ/202001012

Батлагдсан төсөвт өртөг: 23,000,000 төгрөг

Үнийн санал ирүүлэх барааны техникийн үзүүлэлт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минут]**-аас өмнө цахим тендер шалгаруулалтын журмаар авна.

Үнийн саналыг цахим тендерийн журмаар **[2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минут]**-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх. Тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Тээвэрчдийн гудамж, өөрийн байр- 302, Утас: 77002255

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойл олт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн үзүүлэлт шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн үзүүлэлт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, шимтгэл, төлбөрөө тухайн тендер ирүүлсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч илрүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер ирүүлсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь цахим худалдан авах ажиллагааны систем /www.tender.gov.mn/-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: <p align="center">Үнийн саналыг 2020оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим тендер шалгаруулалтын журмаар авна.</p> <p align="center">Үнийн саналыг цахим тендерийн журмаар 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.</p>
ТӨӨЗ 2.3	Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 1 жил 2. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх, жилийн тоо: Сүүлийн 1 жил 3. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жил 4. Улсын бүртгэлийн гэрчилгээ, нотариатаар баталгаажуулах 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт
ТӨӨЗ 3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн үзүүлэлт болон стандартад нийцэж буйг нотлох баримт тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэртэй байна. <ol style="list-style-type: none"> 1. Үнийн санал 2. Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны нэр: “СЕРВЕР ӨРГӨЖҮҮЛЭХ, КАМЕРЖУУЛАХ

Нийлүүлэгдэх бараа, бүтээгдэхүүн нь дор дурьдсан техникийн үзүүлэлт, стандартад нийцсэн байна.

№	Нэр төрөл	Үзүүлэлт	Тоо
Хяналтын камерийн систем өргөтгөхөд			
1	Гадна камер	ZOOM 4 MP 25x Network IP PTZ DOME outdoor camera up to 2560 x 1440 resolution 25x optical zoom 16x digital zoom support H.265 + H265 video compression	5ш
2	Дотор камер	8 MP EXIR DOME 4K Built microphone indoor camera up to 2560 x 1440 resolution 25x optical zoom 16x digital zoom support H.265 + H265 video compression	20ш
3	Бичигч төхөөрөмж	32 channel NVR 4k NVR 16 PoE up to 6 MP resolution recording HDMI and VGA output at up to 1920x1080 Plug & Play with up to 16 independent PoE network interfaces	1ш
4	Хард диск	8 TB Surveillance internal SATA HDD 3.5 inch 256 mb cache for NVR	2ш
5	Тог баригч	UPS up to 1000W	2ш
6	Свич	Switch 16 port 10/100/1000 mpbs PoE	3ш
7	Төхөөрөмжийн хайрцаг	Unit box 6 unit	2ш
8	Сүлжээний кабель	CAT 6 Cable	1100м
9	Цахилгааны кабель	Power Cable outdoor	1100м
10	Сүлжээний толгой	RJ 45 connector	100ш
11	Тэжээлийн толгой	Power connector	100ш
12	Тэжээлийн Блок	Up to 450W (peak) ATX12V	2ш

Байгууллагын серверийн хүчин чадал нэмэгдүүлэх болон сүлжээний төхөөрөмж шинэчлэхэд			
13	Сервер компьютер	PowerEdge T440-тэй дүйцэхүйц Tower Server Intel Xeon 4110 2.1Ghz Silver Processor with 16GB RAM 8 Tb sata hdd	1
14	Рүүтэр	Cisco-тэй дүйцэхүйц RV082 Dual WAN VPN Router	1
15	Свич	Linksys-тэй дүйцэхүйц SE3024 24-Port Gigabit Ethernet Switch	3

Барааг тодорхойлох бичиг баримт: Тендерт оролцогчийн санал болгох бүтээгдэхүүн нь техникийн үзүүлэлтэнд заасантай нийцэж байгааг үйлдвэрлэгчээс нь ирүүлсэн холбогдох зураг, чанарын баталгаа, шаардлагатай бусад бичиг баримтаар баталгаажуулж тендерийн саналдаа хавсаргана. Мөн үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэсэн огноо зэргийг тодорхой заасан гарал үүслийн гэрчилгээг ирүүлнэ.

Барааг шалгаж, хүлээн авах: Нийлүүлж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс олгосон техникийн паспорт дагалдуулан ирүүлнэ. Барааг “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын байранд нийлүүлэгчийн төлөөлөгч хүргэж ирж, камерыг бүрэн суурилуулж, хэвийн үйл ажиллагааг шалгаж хүлээлгэн өгнө. Техникийн паспортгүй, чанарын шаардлага хангаагүй гэж үзсэн барааг захиалагч хүлээн авахгүй, гэрээ байгуулахгүй, төлбөр хийхгүй байх эрхтэй.

Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь:

/Захиалагч энэхүү хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, тендерт оролцогч 8 дугаар баганыг тус тус бөглөнө./

Бараа нийлүүлэх: Гэрээг байгуулснаас хойш ажлын 22 хоног

	Барааны тодорхойлолт	Тоо, ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг /Ажлын талбай/	Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа /Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө/
№	2	3	4	5	6	7	8
1	Гадна камер	5	Ширхэг	Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын байр	2020.03.14	2020.03.30	
2	Дотор камер	20	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
3	Бичигч төхөөрөмж	1	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
4	Хард диск	2	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
5	Тог баригч	2	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
6	Свич	3	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
7	Төхөөрөмжийн хайрцаг	2	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
8	Сүлжээний кабель	1100	Метр		2020.03.14	2020.03.30	
9	Цахилгааны кабель	1100	Метр		2020.03.14	2020.03.30	
10	Сүлжээний толгой	100	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
11	Тэжээлийн толгой	100	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
12	Тэжээлийн Блок	2	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
13	Сервер компьютер	1	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
14	Рүүтэр	1	Ширхэг		2020.03.14	2020.03.30	
15	Свич	3	Ширхэг		2020.03.14	2020.03.30	

Тав.ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], дор дурдсан барааг[санал болгож буй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу /тоо/ хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо, ширхэг	Нэгж, үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших**

1.1. Техникийн үзүүлэлтийг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл /ГТН/-д, эсхүл техникийн үзүүлэлтийг захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт**

2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн үзүүлэлтэд нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
- 3. Оюуны өмчийн эрх**

3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
- 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх**

4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс /INCOTERMS/ буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
- 5. Баталгаат засварын хугацаа**

5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа /тоо/ жил байна.
- 6. Гэрээнд өөрчлөлт оруулах**

6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
- 7. Төлбөр**

7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авсанаас хойш /ГТН-д заасан тоо/ хоногийн дотор шуурхай хийнэ.

- | | |
|---|--|
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн үзүүлэлтэд заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээг үйгээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | | | | | | | | | | | |
|---|---|------|--|------|---|------|---|------|--|------|--|
| 1. Шалгах болон турших /ГЕН-1/ | 1.1. / Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана./ | | | | | | | | | | |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт /ГЕН-2/ | <table border="0"><tr><td>1.1.</td><td>Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</td></tr><tr><td>1.2.</td><td>Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэлийн хувь</td></tr><tr><td>1.3.</td><td>Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт</td></tr><tr><td>1.4.</td><td>Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ</td></tr><tr><td>1.5.</td><td>Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ</td></tr></table> | 1.1. | Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: | 1.2. | Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэлийн хувь | 1.3. | Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт | 1.4. | Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ | 1.5. | Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ |
| 1.1. | Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: | | | | | | | | | | |
| 1.2. | Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэлийн хувь | | | | | | | | | | |
| 1.3. | Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт | | | | | | | | | | |
| 1.4. | Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ | | | | | | | | | | |
| 1.5. | Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ | | | | | | | | | | |

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, **нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хуультогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -аас _____ оны _____ дугаар сарын ____ -ныөдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг ;
Үнийн санал
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан бараа нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
*үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын
*үсэг]*_____

ТАМГА

[нийлүүлэгчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]